



Joint Mongolian-German Project
International Trade Policy/WTO

Ministry of Industry and Trade – German Technical Cooperation
C.P.O.Box 1264 Ulaanbaatar 210613 Mongolia
Phone: +976-11-315464 Fax: +976-11-315955 Mail: trade@gtz-mongolia.org



ДХБ-ын тухай сургалтын хөтөлбөр № 2

**ДЭЛХИЙН ХУДАЛДААНЫ БАЙГУУЛЛАГА БА
МОНГОЛ УЛС**

Монгол Улсын үүрэг амлалт, хэрэгжилтийн асуудлууд

Үйлдвэр, худалдааны яамны Худалдааны бодлого,
хамтын ажиллагааны газраас бэлтгэв.

Улаанбаатар хот, 2003 он

Агуулга

Монгол улс ДХБ-д элссэн нь	2
ДХБ Монгол Улсад яагаад чухал вэ?	3
Импортын гаалийн тариф	3
Дотоодын татварын тогтолцоо	4
Хөдөө аж ахуйн тухай хэлэлцээр	4
Сүлжмэл, нэхмэл бүтээгдэхүүн болон хувцасны тухай хэлэлцээр	5
Худалдаанд хамаарах хөрөнгө оруулалтын арга хэмжээний тухай хэлэлцээр ..	6
Демпингийн эсрэг арга хэмжээний тухай хэлэлцээр	7
Татаас болон нөхөн төлөөсийн арга хэмжээний тухай хэлэлцээр	8
Хамгаалалтын арга хэмжээний тухай хэлэлцээр	9
Гаалийн үнэлгээ	10
Импортын лицензийн журмын тухай хэлэлцээр	11
Худалдаан дахь техникийн саад тотгорын тухай хэлэлцээр	12
Мал эмнэлэг, ургамал хорио цээрийн тухай хэлэлцээр	12
Үйлчилгээний худалдааны ерөнхий хэлэлцээр	13
Оюуны өмчийн эрхийн худалдаатай холбогдсон асуудлын талаарх хэлэлцээр	13
Анхаарах асуудлууд	14

Үйлдвэр, худалдааны яам



ДЭЛХИЙН ХУДАЛДААНЫ БАЙГУУЛЛАГА БА МОНГОЛ УЛС

**ДЭЛХИЙН ХУДАЛДААНЫ БАЙГУУЛЛАГА БА МОНГОЛ УЛС:
МОНГОЛ УЛСЫН ҮҮРЭГ АМЛАЛТ, ХЭРЭГЖИЛТИЙН АСУУДЛУУД**

Улаанбаатар хот, 2003 оны 5 дугаар сар

ДХБ-ын зарчмууд: Монгол Улсын үүрэг амлалт, хэрэгжилтийн асуудлууд

Монгол Улс ДХБ-д элссэн нь

- Монгол Улс Тариф, Худалдааны Ерөнхий Хэлэлцээр/ГАТТ/-т нэгдэн орохоор 1991 онд хүсэлтээ гаргасан.
- Барааны гаалийн тариф болон үйлчилгээний худалдааны талаар 1991-1996 онуудад 10 гаруй оронтой хоёр талын хэлэлцээ хийсэн /АНУ, ЕХ, Канад, Япон, Австрали, Швейцар, Мексик/.
- 1997 оны 1 дүгээр сарын 29-нд Монгол Улс ДХБ-ын 130 дахь гишүүн болсон.

ДХБ МОНГОЛ УЛСАД ЯАГААД ЧУХАЛ ВЭ?

1997 он хүртэл Монгол Улс дэлхийн 70 орчим улстай худалдаа хийж байсны 14 улстай нь худалдааны хэлэлцээртэй буюу нэн тааламжтай үндэстний нөхцлийг мөрдөж байв.

Монгол Улс ДХБ-ын гишүүн болсноор:

- Эдүгээ тус байгууллагын гишүүн 145 оронтой нэн тааламжтай үндэстний нөхцлөөр худалдаа хийх боломжтой болсон.
- ДХБ-ын хүрээнд явагдаж буй үйл ажиллагаа, гишүүн бүх орон болон тус байгууллагад нэгдэхээр ажиллаж буй орнуудын худалдааны бодлого, баримт бичгүүдийн мэдээллээр хангагдах болсон.
- АНУ-ын худалдааны нэн тааламжтай нөхцлийг 1999 оноос ямар нэгэн болзолгүйгээр байнга эдлэх, худалдааны нэмэлт хөнгөлөлтөд нь хамрагдах эрхтэй болсон.
- Монголын нэхмэл бүтээгдэхүүний экспортод тогтоосон тоо хэмжээний хязгаарлалтаа Европын Холбоо 1997 онд цуцалсан.
- Хоёр талын худалдааны харилцаанд Монгол Улсын эрх ашигт сөрөг үр дагавар үзүүлэх тунш орны худалдааны бодлогод олон талт механизмын нөлөөллийг ашиглах боломжтой болсон.
- Монгол Улсын худалдааны гол түншүүдийн нэг БНХАУ ДХБ-д 2001 онд нэгдэн орсноор Хятадын зах зээл манай экспортод илүү нээлттэй болсон.
- ОХУ-ын ДХБ-д нэгдэхээр хийж буй хэлэлцээнд Монгол Улс өөрийн эрх ашгийг хамгаалж оролцох боломжтой болсон.
- Монгол Улс шилжилтийн эдийн засагтай орнуудаас ДХБ-д анх түрүүнд нэгдсэнээр санхүүгийн хувьд сүүлийн жилүүдэд нэгдэхээр ажиллаж буй орнуудтай харьцуулахад ихээхэн хэмнэлт гаргасан.
- ДХБ-ын техник туслалцааны хүрээнд тусламж, дэмжлэг авах бололцоотой болсон.

ДХБ-ын зарчмууд, Монгол Улсын үүрэг амлалт, хэрэгжилтийн асуудлууд

ИМПОРТЫН ГААЛИЙН ТАРИФ

ДХБ-ын гол зарчмууд

- ДХБ-ын бүх гишүүн орнууд Нэн тааламжтай үндэстний нөхцлийг харилцан олгоно.
- Гишүүн орон тус бүр тарифаа бууруулах, цаашид есгөхгүй байх дээд хязгаарыг тогтоосон үүрэг амлалт авна.
- Тарифын зохицуулалтаар дотоодын үйлдвэрлэлийг хамгаална.
- Тарифын бус арга хэмжээг тарифын зохицуулалтанд шилжүүлнэ.

Монгол Улсын үүрэг амлалт

- Нийт барааны импортын тарифын дээд хязгаар- 20%. Гэхдээ:
 - тамхи, хивс, нэхмэл, сүлжмэл бүтээгдэхүүн, модон мебель тавилга зэрэг бараанд- 30%.
 - Шар айраг, цагаан архи, спирт, ликёр зэрэг согтууруулах ундаанд- 25-75%

Хэрэгжилт

Монгол Улсын мөрдөж буй импортын тариф нь ДХБ-д хүлээсэн үүрэг амлалтын дээд хязгаараас доогуур байгаа. Тухайлбал,

1997-15.0%	2001-7.0%	2003-5.0%
2000-5.0%	2002-5.0%	

- Экспорт, импортод тоо хэмжээний хориг, хязгаарлалт байхгүй.
- Цөөн нэрийн бараанд экспорт, импортын лицензтэй.
- Импортыг хязгаарлахад чиглэсэн нэмэгдэл татвар, хураамж байхгүй.

ДОТООДЫН ТАТВАРЫН ТОГТОЛЦОО

ДХБ-ын гол зарчмууд

- Импортын бараанд ногдуулах дотоодын аливаа татвар (НӨТ, онцгой татвар г.м.) нь дотоодын үйлдвэрийн ижил төрлийн бараанд ногдуулж буй татвараас илүүгүй байх;
- Татвар ногдуулах аргачлал адил байх.

Монгол Улсын үүрэг амлалт

Дотоодын болон импортын ижил төрлийн бараанд ногдуулж буй онцгой албан татварын хувь хэмжээг 1997 оны 1 дүгээр сарын 1-нээс ижил түвшинд болгох, ногдуулах аргачлалыг адилтгах

Хэрэгжилт

- Жилийн 10 саяас доош төгрөгийн татвар ногдох борлуулалтын орлоготой үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг НӨТ-аас чөлөөлж байгаа. Энэ заалт импортлогчдод хамаарахгүй байна.
- Дотоодын болон импортын спирт, архи, дарсанд онцгой албан татвар ногдуулах аргачлал өөр өөр байгаа. Тухайлбал, дотоодын шар айргийг онцгой албан татвараас чөлөөлж байгаа, импортын шар айрганд 1 литр тутамд 20 центийн онцгой албан татвар ногдуулж байна
- Дотоодын болон импортын тамхинд онцгой татвар ногдуулж буй аргачлал, онцгой албан татварын хувь хэмжээ /100 ширхэгт 30 цент/ адил байна

ХӨДӨӨ АЖ АХУЙН ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭР

Уругвайн үе шатны /1986-1994/ хэлэлцээний үр дүн

- Хөдөө аж ахуйн талаар тусгай хэлэлцээр байгуулсан.
- Тарифын болон тарифын бус арга хэмжээгээр хамгийн их хамгаалагдсан, хамгийн их татаас олгогддог бүтээгдэхүүний зах зээлийг нээлттэй, шударга болгоход чиглэсэн удаан хугацааны хөтөлбөр, зорилтыг тодорхойлсон. Үүнд:

1. Зах зээлийг нээлттэй болгох

- Тарифын бус арга хэмжээг тарифын зохицуулалтад шилжүүлэх;
- Импортын татварын хэмжээг хөгжингүй орнууд 1995-2000 онд 36%-иар, хөгжиж буй орнууд 1995-2004 онд 24%-иар тус тус бууруулах;
- Орон тус бүр ХАА-н бүх бүтээгдэхүүнд импортын тарифын дээд хязгаарыг тогтоох.

2. Татаас /дотоодын дэмжлэг/-ыг багасгах

ХАА-н бүтээгдэхүүний үйлдвэрлэгчдэд олгож буй татаасыг: хөгжингүй орнууд 1995-2000 онд 20%-иар, хөгжиж буй орнууд 1995-2004 онд 13.3%-иар тус тус бууруулна.

ХӨДӨӨ АЖ АХУЙН ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭР

3. Экспортын татаасыг багасгах

Экспортын татаасыг хөгжингүй орнууд 1995-2000 онд барааны үнийн дүнгийн 34%, тоо хэмжээний хувьд 21%-иар, хөгжиж буй орнууд 1995-2004 онд барааны үнийн дүнгийн 24%-иар, тоо хэмжээний хувьд 14%-иар тус тус бууруулна.

4. ХАА-н бүтээгдэхүүний зах зээл, хамгаалалтыг чөлөөлөх үйл явцыг үргэлжлүүлэх

Хөдөө аж ахуйн хэлэлцээг 1999 оноос үргэлжлүүлэх.

Хэрэгжилт

- ХАА-н бүх бүтээгдэхүүний хувьд импортын тарифын дээд хязгаарыг тогтоосон үүрэг амлалт авсан, мөрдөж буй тариф энэ хязгаарт багтаж байгаа.
- Худалдаанд сөрөг нөлөө үзүүлэх, багасгавал зохих дотоодын болон экспортын татаас олгодоггүй.
- Хэлэлцээрээр зөвшөөрөгдсөн арга хэмжээнд төсвөөс татаас олгож байгаа. Тухайлбал малын эм, бэлдмэлд 2001 онд 2.9 тэрбум, 2002 онд 3.2 тэрбум төгрөгийн татаас олгосон.
- 2000 оны 3 дугаар сард Женев хотноо эхэлсэн ХАА-н хэлэлцээнд Монгол Улс оролцож, хөгжингүй орнуудын татаасыг багасгах, ХАА-н бүтээгдэхүүний аюулгүй байдал, хөгжиж буй орнуудад үзүүлэх тусгай хөнгөлөлттэй нөхцөл зэрэг асуудлаар сонирхогч орнуудтай байр сууриа нэгтгэн ажиллаж байна.

ДХБ-ын зарчмууд, Монгол Улсын үүрэг амлалт, хэрэгжилтийн асуудлууд СҮЛЖМЭЛ, НЭХМЭЛ БҮТЭЭГДЭХҮҮН БОЛОН ХУВЦАСНЫ ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭР

Хэлэлцээрийн зорилго

Сүлжмэл, нэхмэл бүтээгдэхүүний экспортод мөрдөж буй тоо хэмжээний хязгаарлалтыг цуцлах талаар импортлогч орнууд шат дараалсан арга хэмжээ авна.

Хэлэлцээрийн зарчим

Хэлэлцээрийн хавсралт жагсаалтанд заасан сүлжмэл, нэхмэл бүтээгдэхүүнийг дараах дөрвөн үе шатаар тоо хэмжээний хязгаарлалтаас чөлөөлнө. Үүнд:

- 1995 онд жагсаалтад дурьдсан бүтээгдэхүүний 16%-ийг
- 1998 онд - 17%-ийг
- 2002 онд - 18%-ийг
- 2005 онд - 49%-ийг, улмаар сүлжмэл, нэхмэл бүтээгдэхүүний импортыг тоо хэмжээний хязгаарлалтгүй болгох.

ДХБ-ын зарчмууд, Монгол Улсын үүрэг амлалт, хэрэгжилтийн асуудлууд

СҮЛЖМЭЛ, НЭХМЭЛ БҮТЭЭГДЭХҮҮН БОЛОН ХУВЦАСНЫ ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭР

Монгол Улсын экспортод сүлжмэл, нэхмэл бүтээгдэхүүний эзлэх хувь /%I



ДХБ-ын зарчмууд, Монгол Улсын үүрэг амлалт, хэрэгжилтийн асуудлууд

ХУДАЛДААНД ХАМААРАХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭР

Хэлэлцээрийн зорилго

Худалдаанд сөрөг нөлөө үзүүлж буй гадаадын хөрөнгө оруулалт (ГХО)-ын арга хэмжээг олон улсын худалдааны журамд хамруулах, ийм арга хэмжээг шатчилан цуцлах, хориглох

Дотоодын бараанд илүү таатай нөхцөл олгосон, импортыг тоо хэмжээгээр хязгаарласан дараах арга хэмжээнүүдийг худалдаанд сөрөг нөлөө үзүүлж буй, хоригловол зохих ГХО-ын оруулалтын арга хэмжээ гэнэ.

- ГХО-тай ААН өөрийн үйлдвэрлэлд дотоодын бараа бүтээгдэхүүн худалдан авч байх;
- ГХО-тай ААН-ийн импорт, экспортынх нь хэмжээнээс илүүгүй байх;
- ГХО-тай ААН-ийн гадаад валют ашиглах боломжийг олж буй гадаад валютын орлогын хэмжээгээр хязгаарлах (улмаар импортлох боломжийг хязгаарлах);
- ГХО-тай ААН үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийхээ тодорхой хэсгийг дотоодод борлуулах (улмаар экспортыг хязгаарлах).

Хэрэгжилт

Монгол Улсын өнөөгийн мөрдөж буй "Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль"-д худалдаанд сөрөг нөлөө үзүүлж буй дээрх арга хэмжээний тухай заалт байхгүй.

ДЕМПИНГИЙН ЭСРЭГ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭР

Демпинг-Барааг дотоод зах зээлийн ердийн үнээс доогуур үнээр гадаад орны зах зээлд экспортлох үйл ажиллагаа.

Импортлогч орны дотоодын үйлдвэрлэлд демпингийн үзүүлэх сөрөг нөлөө:

Дотоодын ижил төрлийн бүтээгдэхүүний борлуулалт, дотоод үнэ, үйлдвэрлэлийн ашиг орлого, зах зээлд эзэлж буй хувь хэмжээ, хөрөнгө оруулалтын үр ашиг, хүчин чадлын ашиглалт буурах, улмаар ажилгүйдэл бий болох, ажилчдын цалин хөлс багасах

Хэлэлцээрийн гол зарчмууд

- Демпингийн үнэ бүхий импортын сөрөг нөлөөлөлд өртсөн дотоодын үйлдвэрлэлийн салбар ийм импортын талаар магадлан шалгалт явуулахыг хүссэн өргөдлийг Засгийн газартаа гаргана.
- Импортлогч орны хяналт, шалгалтын холбогдох байгууллага демпингийн эсрэг магадлан шалгалт хийх болсон тухайгаа экспортлогч орны Засгийн газарт мэдэгдэнэ.
- Тухайн барааны импорт демпингийн үнээр орж ирсэн, үүний улмаас ижил төрлийн барааны дотоодын үйлдвэрлэлд хохирол учирсан нь магадлан шалгалтаар тогтоогдвол импортлогч орон ийм бараанд демпингийн эсрэг татвар ногдуулна.

ДЕМПИНГИЙН ЭСРЭГ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭР

Монгол Улсын үүрэг амлалт

- Демпингийн эсрэг арга хэмжээний тухай хэлэлцээрийг мөрдөнө.
- Демпингийн эсрэг арга хэмжээний талаар үндэсний хууль тогтоомжиндоо тусгана.

Хэрэгжилт

- Монгол Улсын “Гаалийн тарифын тухай хууль”-ийн 8 дугаар зүйл: “Монгол Улсын Засгийн газар гаалийн татвараас гадна демпингийн эсрэг нэмэгдэл татвар ногдуулж болно”
- Монгол Улсад демпингийн эсрэг арга хэмжээний тухай тусгайлсан хууль байхгүй, гаргах шаардлагатай (СЭЗЯ, УГЕГ).
- Демпингийн үнэ бүхий импорт одоогоор ажиглагдахгүй байгаа боловч цаашид бий болохыг үгүйсгэхгүй.

ТАТААС БОЛОН НӨХӨН ТӨЛӨӨСИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭР

Хэлэлцээрийн хамрах хүрээ: Аж үйлдвэрийн бүтээгдэхүүнд олгож буй татаас

Хэлэлцээрийн зорилго: Улс орнууд, түүний дотор хөгжиж буй орнуудын эдийн засгийн хөгжилд татаас чухал үүрэг гүйцэтгэж байгааг хүлээн зөвшөөрөхийн зэрэгцээ бусад орны худалдаа, үйлдвэрлэлд сөрөг нөлөө үзүүлэх татаасыг хориглох.

Татаасын хэлбэр

- ЗГ-аас тусламж олгох, арилжааны банкны зээлээс илүү хөнгөлөлттэй зээл олгох, ЗГ-аас зээлийн төлбөрийн баталгаа гаргах.
- ЗГ зах зээлийн үнээс илүү тааламжтай үнээр бараа нийлүүлж, үйлчилгээ үзүүлэх, бараа худалдан авах.

Татаасын төрөл

- **Хориглосон татаас (“улаан багц”):**
 - Экспортын татаас: Хөгжиж буй орнууд энэ татаасыг 2003 оны 1 дүгээр сарын 1 гэхэд цуцалсан байх ёстой. Хэрэв цаашид үргэлжлүүлэх шаардлагатай гэж үзвэл 2002 онд энэ талаар ДХБ-д хүсэлт гаргана.
 - Дотоодын бараа, түүхий эд хэрэглэхийг урамшуулсан татаас- Хөгжиж буй орнууд 2001 он гэхэд энэ татаасыг цуцалсан байх ёстой.

ТАТААС БОЛОН НӨХӨН ТӨЛӨӨСИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭР

- **Зөвшөөрөгдсөн татаас (“шар багц”):** Тодорхой үйлдвэр, эсвэл бүлэг үйлдвэрт олгож буй татаас; үйлдвэрийн тодорхой салбарт олгож буй татаас; тодорхой бүс нутагт олгож буй татаас багтана. Эдгээр татаас нь бусад орны худалдаа, үйлдвэрлэлд сөрөг нөлөө үзүүлэх тохиолдолд импортлогч орон ийм татаастай бараанд нөхөн төлөөсийн татвар ногдуулж болно.
- **Зөвшөөрөгдсөн татаас (“ногоон багц”):** Ямар нэгэн тодорхой салбар, үйлдвэрт зориулагдаагүй байх. Жижиг, дунд үйлдвэр, шинжлэх ухааны судалгаа шинжилгээний ажил, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг байгаль орчныг хамгаалах шинэ шаардлагад нийцүүлэх, буурай хөгжилтэй бүс нутгийн үйлдвэрийн хөгжлийг дэмжихэд олгож буй татаасууд хамрагдана.

Нөхөн төлөөсийн татвар

“Ногоон багц” дахь бараанд импортлогч орон нөхөн төлөөсийн татвар ногдуулахгүй.

- “Улаан багц”, “шар багц” дахь бараа импортлогч орны худалдаа, үйлдвэрлэлд сөрөг нөлөө үзүүлж байгаа нь тогтоогдвол импортлогч орон эдгээр бараанд нөхөн төлөөсийн татвар ногдуулж болно.
- Нөхөн төлөөсийн татвар нь татаасын хэмжээнээс илүү байж болохгүй.
- Импортлогч оронд сөрөг нөлөө үзүүлж буй татаасыг тогтоох, тооцох аргын талаар гишүүн орнууд үндэсний хууль тогтоомжиндоо тодорхой заасан байна.

ТАТААС БОЛОН НӨХӨН ТӨЛӨӨСИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭР

Монгол Улсын үүрэг амлалт

- Гадаадын хөрөнгө оруулалтын хуулийн дагуу олгож байгаа экспортын татаасыг 2002 онд багтаан цуцлах.
- Мөн хуулиар зарим салбарт үзүүлж байгаа татварын чөлөөлөлт, хөнгөлөлт болон экспортын татаасын хүрээг цаашид өргөжүүлэхгүй байх.
- Хориглосон татаасыг цаашид олгохгүй байх.

Хэрэгжилт

- Гаалийн тарифын тухай хуулийн 8 дугаар зүйл: "Монгол улсын Засгийн газар гаалийн татвараас гадна нөхөн төлөөсийн нэмэгдэл татварыг ногдуулж болно".
- 1993 оны Гадаадын хөрөнгө оруулалтын хуулийн дагуу олгосон орлогын албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн хугацааг сунгах хүсэлтээ ДХБ-д тавиад байна.
- Гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын чөлөөлөлтөөс 1998 онд импортын түүхий эд, сэлбэг материалыг хассан бөгөөд 2001 оноос гаалийн импортын татвар, НӨТ-өөс гагцхүү тэргүүлэх салбар болон экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг чөлөөлдөг болж татварын чөлөөлөлтийг багасгасан.
- Нөхөн төлөөсийн татварын арга хэмжээний тухай тусгайлсан хууль тогтоомж одоогоор манайд байхгүй, байх шаардлагатай (СЭЗЯ, УГЕГ)

ХАМГААЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭР

Хэлэлцээрийн зорилго

Тарифын болон тарифын бус арга хэмжээний либералчлал, өсөн нэмэгдэж буй импортын өрсөлдөөнөөс дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах, улмаар тухайн үйлдвэрлэлд бүтцийн өөрчлөлт, технологийн шинэчлэлт хийх, өрсөлдөх чадварыг нь дээшлүүлэх боломж олгох.

Хэлэлцээрийн гол зарчмууд

Тухайн барааны импортын тоо хэмжээний өсөлт нь ижил төрлийн барааны дотоодын үйлдвэрлэлд ноцтой хохирол учруулж байгаа, эсвэл тийм хохирол учруулж болзошгүй тохиолдолд импортлогч орон тодорхой хугацаанд хамгаалалтын арга хэмжээ авч болно (ноцтой хохиролд тухайн салбар бүхэлдээ, эсвэл түүний зонхилох хэсэг өртөгдсөн байх тохиолдолд).

Ноцтой хохирол- Дотоодын тухайн үйлдвэрлэлийг бүхэлд нь мэдэгдэхүйц доройтуулсан нөхцөл байдал бий болсныг хэлнэ.

Ноцтой хохирлыг тогтооход магадлан шалгах үзүүлэлтүүд

- Тухайн барааны импортын өсөлтийн хувь хэмжээ;
- Өсөн нэмэгдсэн импортын дотоодын зах зээлд эзлэх хувь хэмжээ;

ХАМГААЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭР

- Ижил төрлийн бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэл, борлуулалт, хүчин чадал, бүтээмж, ашиг, алдагдал, ажил эрхлэлтийн төвшингийн өөрчлөлт.

Хамгаалалтын арга хэмжээний төрөл

- Тухайн бараанд ДХБ-тай тохирсон тарифын дээд хязгаараас өндөр хэмжээний импортын татвар тогтоох.
- Тоо хэмжээний хязгаарлалт тогтоох.

Хамгаалалтын арга хэмжээний үргэлжлэх хугацаа

- Дээд тал нь 4 жил, шаардлагатай бол дахин 4 жилээр сунгаж болно.

Хамгаалалтын арга хэмжээг нэвтрүүлэхээс өмнө магадлан шалгах үйл ажиллагаа явуулах

- Засгийн газрын санаачилгаар;
- Тухайн барааны үлэмж хэсгийг үйлдвэрлэгчдийн шаардлагаар.

Нөхөн төлбөр

- Хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлж буй импортлогч орон тухайн арга хэмжээ хэрэгжүүлсний сөрөг үр дагаварын нөхөн төлбөрийг эрх ашиг нь хөндөгдсөн экспортлогч оронд санал болгох үүрэгтэй.
- Монгол Улс дотоодын үйлдвэрлэл, зах зээлээ хамгаалах бодлогын хүрээнд хамгаалалтын арга хэмжээний талаар холбогдох хууль, тогтоомж гаргах шаардлагатай (СЭЗЯ, ҮХЯ).

ГААЛИЙН ҮНЭЛГЭЭ

Хэлэлцээрийн зорилго

Гаалийн үнэлгээг бодит үнийг үндэслэн хийх, шударга импортлогчдын эрх ашгийг хамгаалах.

Хэлэлцээрийн зарчмууд

- Гаалийн үнэлгээг импортлогчийн бодит төлсөн үнэ дээр тулгуурлан хийх;
- Гаалийн байгууллага гаалийн үнэлгээ хийхдээ үзэмжээр хандах явдлыг хязгаарлах;
- Гаалийн байгууллагын үнэлгээг эс зөвшөөрсөн тохиолдолд импортлогч нь гаалийн байгууллагын удирдлага, шүүхийн байгууллагад хандах эрхтэй;
- Гишүүн орнууд гаалийн үнэлгээний тухай дотоодын журмыг ижилтгэх.

Монгол Улсын үүрэг амлалт

- Хэлэлцээрийг ДХБ-д нэгдэн орсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.
- Дотоодын хууль, тогтоомжийг хэлэлцээрийн заалтанд нийцүүлнэ.

Хэрэгжилт

- 1996 онд шинээр батлан гаргасан “Гаалийн тарифын тухай” хуульд гаалийн үнэлгээ хийх аргуудыг тодорхойлсон.
- Засгийн газрын 2001 оны 63 дугаар тогтоолоор “Импортын барааны гаалийн үнийг тодорхойлох аргачлал”-ыг батлан гаргасан.
- Гаалийн үнийг мэдүүлдэг байх журам тогтоож, гаалийн үнийн мэдээллийн сан байгуулсан.
- Гаалийн үнэлгээний тухай төрөлжсөн цуврал сургалт зохион байгуулж байна.

ИМПОРТЫН ЛИЦЕНЗИЙН ЖУРМЫН ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭР

Хэлэлцээрийн гол зарчмууд

- Импортын лиценз нь худалдааны бодлогыг хэрэгжүүлэх хэрэгсэл мөн;
- Импортын лицензийн журам нь хялбар, ил тод байх;
- Лиценз нь импортод хориг саадын нөлөөлөл үзүүлэхгүй байх;
- Лицензийг засаг захиргааны аль болох нэг байгууллагаас олгож байх;
- Хүсэлт гаргасан гишүүн оронд импортын лиценз олголт, импортын лицензтэй барааны талаар статистик, мэдээлэл өгч байх;

Лицензийн төрөл

Шууд олгох лиценз:

- Энэ төрлийн лицензийг статистик бүртгэлийн зорилгоор хэрэглэдэг.
- Ямар ч тохиолдолд олгогдож байх ёстой.
- Өргөдөл авснаас хойш ажлын 10 хоногт багтааж олгоно.

Шууд бус лиценз:

- Импортыг тодорхой хэмжээгээр хянах, хязгаарлах зорилгоор энэ төрлийн лицензийг хэрэглэдэг.
- Өргөдөл авснаас хойш 30 хоногт багтааж олгоно.

ИМПОРТЫН ЛИЦЕНЗИЙН ЖУРМЫН ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭР

Монгол Улсын үүрэг амлалт

- Монгол Улс ДХБ-д нэгдэн орсноос хойш импортын лицензийн хүчинтэй байх хугацааг нэг жил болгож сунгана.
- Лицензийн тогтолцоог хүн, амьтан, ургамал болон хүрээлэн байгаа орчныг хамгаалах зорилгоор хэрэглэнэ.
- Лицензийн журам, хэрэгжилтийн явцыг ДХБ-д мэдээлж байна.

Хэрэгжилт

Засгийн газрын 2002 оны 219 дүгээр тогтоолоор “Экспорт, импортын лиценз олгох журам”-ыг шинэчлэн баталсан:

- Лицензийг салбарын холбогдох яамд олгож байна.
- Лицензтэй барааг БТКУС-аар коджуулснаар лицензтэй барааны тоо багассан.
- Импортын лицензэнд 19 бүлэг нэрийн бараа хамрагдаж байсныг 9 болгож цөөлсөн.
- Лицензийг нэг жил хүртэл хугацаагаар олгож байна.
- Лицензийг ажлын 21 хоногт багтаан олгоно.

ХУДАЛДААН ДАХЬ ТЕХНИКИЙН СААД ТОТГОРЫН ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭР

Хэлэлцээрийн хамрах хүрээ

- Техникийн зохицуулалт ба стандарт;
- Тохирлын үнэлгээ явуулах журам;
- Мэдээлэл, лавлагааны төв ажиллуулах;

Монгол Улсын үүрэг амлалт

- Стандартчилалын хууль, эрх зүйн баримт бичгийг олон улсын жишигт нийцүүлэх;
- Үндэсний стандартыг олон улсын стандарттай ижилтгэх;
- Импортын барааны чанарын баталгаа, сертификат, баглаа боодлын шаардлага, хяналт нь дотоодын бараатай адил байх, стандарт, чанарын шаардлагыг импортыг хязгаарлах хэлбэрээр хэрэглэхгүй байх.

Хэрэгжилт

- Чанарын баталгаажуулалтын талаар ОХУ, БНХАУ-тай Засгийн газар хоорондын хэлэлцээрүүд байгуулсан.
- "Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай" хуулийг УИХ-аас батлав.
- Стандарт Хэмжилзүйн Төв нь худалдаан дахь техникийн саад тотгорын үндэсний мэдээлэл, лавлагааны төвийн үүргийг гүйцэтгэж байна.

МАЛ ЭМНЭЛЭГ, УРГАМЛЫН ХОРИО ЦЭЭРИЙН ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭР

Хэлэлцээрийн гол зарчмууд

- Хүн, амьтны эрүүл мэндийг хамгаалах;
- Хүнийг ургамал, амьтны өвчнөөс хамгаалах;
- Ургамал, амьтныг элдэв өвчнөөс хамгаалах;
- Эрүүл ахуй, хорио цээрийн арга хэмжээг 2 талын гэрээ, хэлэлцээрээр зохицуулах.

Хэлэлцээрээр хүлээх үүрэг

- Мал, амьтан, ургамлын эрүүл ахуйн хамгаалалтыг худалдаанд сөргөөр нөлөөлөхгүй байх хэлбэрээр хэрэгжүүлэх.

Хэрэгжилт

- Мал эмнэлэг, хорио цээрийн салбарт ОХУ, БНХАУ, Вьетнам, Казахстан, Индонез, Турк, Унгар, БНСУ, Болгар Улстай,
- Ургамалын эрүүл ахуй, хорио цээрийн салбарт- БНХАУ, ОХУ, Унгар, Казахстан, Украин, Болгар, Вьетнам, Индонез Улстай тус тус хэлэлцээрүүд байгуулсан.

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУДАЛДААНЫ ЕРӨНХИЙ ХЭЛЭЛЦЭЭР

Хэлэлцээрийн зорилго

Үйлчилгээний худалдааг олон улсын худалдааны дэг журамд хамруулах.

Хэлэлцээрийн гол зарчмууд:

- Үйлчилгээний худалдаанд нэн тааламжтай үндэстний нөхцлийг харилцан олгох;
- Тухайн орны үүрэг амлалтын жагсаалтанд орсон үйлчилгээний салбараар гадаад орны үйлчилгээ үзүүлэгчдэд үндэстний нөхцөл эдлүүлэх.

Монгол Улсын үүрэг амлалт

- Монгол Улсын тусгай үүрэг амлалтын жагсаалтад тусгагдсан бизнесийн үйлчилгээ, харилцаа холбоо, барилга, бөөний худалдаа, санхүүгийн үйлчилгээ, аялал жуулчлалын салбарын зах зээлийг нээлттэй болгох.

Хэрэгжилт

- Үүрэг амлалт авсан салбаруудад гадаадын үйлчилгээний байгууллагууд салбараа нээх, үйл ажиллагаагаа явуулахад элдэв, хориг хязгаар тавихгүй байгаа.
 - Монголд шуудангийн үйлчилгээ явуулж буй Монгол шуудан компаниас гадна өрсөлдөөн нэвтэрч "DHL", "Си-Эй Эс Интернешнл", "Айр Карго Экспресс", "И-Линк Экспресс", "Блу Монголиа Интернешнл", "Улаанбаатар шуудан" зэрэг компаниуд үйл ажиллагаагаа явуулж байна.
 - 2001 оны 12 дугаар сарын 31 хүртэл Цахилгаан холбоо ХК-д олгосон улс хоорондын үйлчилгээний монополь эрхийгааг 2002 оны 1 дүгээр сарын 1-нээс цуцалсан. Өрсөлдөөн нэвтэрч Skytel, Mobicom зэрэг компаниуд үүрэн телефоны үйлчилгээг явуулж байна.

ОЮУНЫ ӨМЧИЙН ЭРХИЙН ХУДАЛДААТАЙ ХОЛБОГДСОН АСУУДЛЫН ТАЛААРХ ХЭЛЭЛЦЭЭР

Хэлэлцээрийн зорилго

- Оюуны өмчийн эрхийг үр нөлөөтэй, зүй зохистой хамгаалах;
- Оюуны өмчийн эрхийн хамгаалалт нь худалдаанд саад тотгор учруулахгүй байх;
- Шинэ технологийг ашиглагч, үйлдвэрлэгчдэд харилцан ашигтай байх зарчмаар нэвтрүүлэх, түгээх;

Хэлэлцээрийн гол зарчмууд

- Оюуны өмчийн эрхийг хамгаалахад гишүүн орон бүр мөрдвөл зохих наад захын стандартыг тогтоосон байна.
- Гишүүн орнууд оюуны өмчийн салбарт хамаарах олон улсын бусад гэрээ, конвенцийг даган мөрдөнө.
- Парис /Аж үйлдвэрийн өмч/, Берн /Зохиогчийн эрх/-ийн конвенциудыг хэрэгжүүлэхэд үндэстний нөхцлийг баримтлана.
- Гишүүн орнууд газар зүйн заалтын талаарх зарим үйлдэл (Парисын конвенцийн 10 дугаар зүйлийн дагуу шударга бус өрсөлдөөнд тооцогдох хэлбэрийг ашиглах, олон түмнийг барааны газар зүйн үүслийн талаар будлиулах хэрэгслийг барааны заалт, танилцуулгад ашиглах)-ийг зогсоох хуулийн боломжийг сонирхогч талуудад олгоно.

ОЮУНЫ ӨМЧИЙН ЭРХИЙН ХУДАЛДААТАЙ ХОЛБОГДСОН АСУУДЛЫН ТАЛААРХ ХЭЛЭЛЦЭЭР

Монгол Улсын үүрэг амлалт

Монгол Улс ДХБ-д нэгдэн орсон өдрөөс эхлэн Хэлэлцээрийн бүх зүйл, заалтыг бүрэн хэмжээгээр дагаж мөрдөнө.

Хэрэгжилт

- Патент, бүтээгдэхүүний загвар, зохиогчийн эрхийн талаарх зохицуулалтыг боловсронгуй болгож, Патентын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Зохиогчийн эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулаад байна.
- Оюуны өмчийн улсын хяналтын албыг 2000 онд байгуулж, одоогоор 1 ерөнхий байцаагч, 2 ахлах байцаагч, 17 улсын байцаагч ажиллаж байна.
- “Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай” хуулийн төслийг УИХ-д өргөн бариад байна.
- Оюуны өмчийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, эрх зөрчсөн гэм буруутай албан тушаалтан, этгээдэд хуулийн дагуу хариуцлага, торгууль ногдуулах, хуурамч, дуураймал, хууль бус бараа бүтээгдэхүүнийг хураан авч устгах зэргээр оюуны өмчийн эрхийн хамгаалалтыг хэрэгжүүлэхэд Оюуны өмчийн улсын хяналтын алба, шүүх, цагдаа, гаалийн байгууллагын гүйцэтгэх үүрэг чухал ач холбогдолтой.

Анхаарах асуудлууд:

ДХБ-д өгөх мэдээлэл:

- Монгол Улсын ДХБ-ын өмнө хүлээсэн үүрэг амлалтын 35 (Ил тод байдал), 48 (хөнгөлөлттэй нөхцөл олгож буй худалдааны хэлэлцээр), 60 дугаар зүйл (ХАА-н тухай, Ариун цэвэр, хорио цээрийн тухай, Импортын лицензийн тухай, ТХЕХ-1994-ийн 7 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хэлэлцээр болон худалдааны саад тотгорын тухай хэлэлцээрүүд)-ийн дагуу ДХБ-д мэдээлэл өгөх.
- Худалдаатай холбогдол бүхий хууль, тогтоомжийг англи хэлэнд орчуулан ДХБ-д мэдээлэх.

Үүрэг амлалт 24: Засгийн газар боловсруулаагүй ноолуурын экспортын хоригийг 1996 оны 10 дугаар сарын 1 хүртэл хадгалж, цаашид үнийн дүнгийн 30 хувиас хэтрэхгүй хэмжээний экспортын татвар тогтооно. Экспортын тэрхүү татварыг Монгол Улс ДХБ-д нэгдэн орсноос хойш 10 жилийн туршид зохих шатлалыг дамжин хална.

(1996 оны 3 дугаар сарын 29-ний өдөр батлагдан гарсан “Зарим бараанд ногдуулах экспортын гаалийн татварын хэмжээ тогтоох тухай Монгол улсын хууль”-иар боловсруулаагүй 1кг ямааны ноолуур тутамд 4000 төгрөгийн гаалийн албан татвар ногдуулж байна.)

Анхаарах асуудлууд:

Үүрэг амлалтын 44 дүгээр зүйл: Худалдаанд хамаарах бүх хууль, тогтоомжийг шинж чанараас нь үл хамааран мөрдөж эхлэхээс өмнө Парламент болон Засгийн газрын албан ёсны сонин болох "Ардын эрх", эсхүл "Засгийн газрын мэдээ" сонинд Засгийн газар болон худалдаачид танилцаж чадахуйцаар хэвлэн нийтлэх.

Үүрэг амлалт 50, 51:

- Чөлөөт бүсийн тухай хууль болон авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар ДХБ-д мэдээлэх.

- Монгол Улсад чөлөөт худалдааны бүс байгуулагдсан нөхцөлд энэ бүсэд үйлдвэрлэгдсэн бараа Монгол Улсын бусад хэсэгт худалдаалагдвал эдгээр бүтээгдэхүүн болон тэдгээрийн импортын бүрэлдэхүүн хэсэгт Монгол Улс мөрдөгдөж буй бүх төрлийн татвар, тариф, гаалийн хураамж болон бусад зохицуулалтыг хэрэглэх.

- Чөлөөт бүсэд фирм байгуулахтай холбогдсон хөнгөлөлтүүдийн тухайд ДХБ-ын татаас болон нөхөн төлөөсийн арга хэмжээний тухай хэлэлцээрийн заалтыг биелүүлэх.

Үүрэг амлалт 59:

ДХБ-ын Засгийн газрын худалдан авах ажиллагааны тухай Хэлэлцээрийн хороонд ажиглагчийн статустайгаар оролцох.